

НЭХМЭЛИЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТЕХНОЛОГИ

**Стандарт 10. Багшлах
бүрэлдэхүүний заах аргын
чадамжийг сайжруулах**



CDIO –г хэрэгжүүлэхээс өмнөх үйл ажиллагаа

Их сургуулийн багшлах бие бүрэлдэхүүн ажиллах эхний жилүүдэд сурганы курст суралцахаас өөр дахин заах аргын сургалтанд хамрагдаж байгаагүй.

Улиралд тодорхой тоогоор үзүүлэн болон нээлттэй хичээлд суух хүрээнд заах аргын сургалт хязгаарлагдаж байсан.

CDIO- г хэрэгжүүлэх үеийн үйл ажиллагаа (1)

- 2015 оны 10 сарын 20-21нд "CDIO Teaching and Learning Framework"
- 2015 оны 11 сарын 09-13нд "Designing an integrated curriculum"
- 2016 оны 03 сарын 28наас 04 сарын 01-нд "Conceiving and designing innovative products and systems"
- 2016 оны 04 сарын 04-07 нд "Designing active experiential learning experiences"
- 2016 оны 05 сарын 10-12 "Evaluating programs for continuous improvement" сургалтанд хамрагдан CDIO арга технологи, системийг судалсан.

CDIO- г хэрэгжүүлэх үеийн үйл ажиллагаа (2)

- Хөтөлбөрт тусгагдсан хичээлүүдийг зааж буй багш бүр сургалтын идэвхитэй аргыг ашиглаж байна. Эдгээр нь хөтөлбөрийн хичээлүүдийн стандартад тусгагдсан болно. Хөтөлбөрийн үнэлгээний үед багш Д. Энхтуяа, П. Туул, Б. Болормаа, М. Баяр, П. Булга нар сургалтын идэвхитэй аргыг ашигласан үр дүнгээр үзүүлэн хичээл заасан нь зохих түвшинд явагдаж байна гэж үнэлүүлсэн.

Цаашид хийгдэх ажил

Хөтөлбөрийн багш бүр заах аргын чадамжийг сайжруулах төлөвлөгөөтэй болох, их сургууль, бүрэлдэхүүн сургууль, салбар багшийн хөгжлийг дэмжих төлөвлөгөөгэй болох, ажлаа хэрэгжүүлэх хөтөлбөр боловсруулж мөрдлөгө болгон ажиллахад анхаарах.

Голлох үр өгөөж, үр дүн

- Хөтөлбөрийн нийт багш нар заах аргын чадамжийг сайжруулж сургалтын идэвхитэй аргыг хэрэглэх болсон.
- Багш бүр хичээлийн стандартаа шинэчлэн боловсруулсан. Энд заах аргын шинэчлэл шаардагдаж байгаа.

Хэрэгжүүлэх явцад илэрсэн давуу болон сул тал

Давуу онцлог тал:

Багш нарт хичээлийн багш биш, хөтөлбөрийн багш болох хандлага төлөвшсөн. Багш бүр заах аргын чадамжийг сайжруулахад анхаарч оюутантай ажиллах идэвхи, санаачлага нэмэлдсэн.

Сул тал:

Хөтөлбөрийн багш нар бүгд ижил түвшинд сургалтанд хамрагдаагүй, их сургуулийн багшийн хөгжлийг дэмжих төлөвлөгөө, хөтөлбөр бүрэн танигдаагүй байгаа нь өнөөдрийн сул тал болно.